

валенкогийн толилуулан буй номын ач холбогдол бүр ч чухал юм.

Азийн энх тайван, хамтын аюулгүй байдлын төлөө тэмцлийн өнөөгийн үе шатанд гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, цаашдын хэтийн төлөвийг тодорхойлж өгсөнд энэ судалгааны үнэ цэнэ оршино. Зохиогч номынхоо төгсгөлд хамтын аюулгүй байдлын тухай зөвлөлтийн санал бол бэлэн төлөвлөгөө биш, Ази болон дэлхий дахинд гарсан өөрчлөлтийг харгалзан үзсэн үр бүтээлтэй үзэл санаа юм гээд Азийн орнууд хамтын үндсэн дээр нарийвчлан судлаж үзсэн шинэ санаачилга, санал дэвшүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэр-

хийлжээ.

ЗХУ-аас дэвшүүлсэн Азийн хамтын аюулгүй байдлын тухай үзэл санаатай нягт уялдуулан Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах саналыг БНМАУ саяхан дэвшүүлсэн билээ. Энэ санал нь Азийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэх, Азид бат бэх энх тайван тогтоох явдалд тус дөхөм үзүүлэх гэсэн энхийг эрхэмлэгч монголын ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлж байгаа юм.

**Ц. Батбаяр**

**ЁСИДА МИНОРУ «МОНГОРУ ХАККЕН» ТОКИО, 1979, 309 р.  
(Ёсида Минору «Монголыг үзсэн нь» Токио. 1979)**

Японы улс төр, олон нийтийн зүтгэлтэн, парламентийн гишүүн Ёсида Минору 1978 онд БНМАУ-д айлчилсан хугацаандаа олж танилцсан баримт материалд түшиглэж «Монголыг үзсэн нь» (Нүүдэлчин үндэстний гайхамшиг) гэсэн ном бичиж хэвлүүлжээ. Уг ном «Монголын түүх ба Япон-Монголын харилцаа», «Орчин үеийн Монгол», «Монгол улс 1978 оны зун» гэсэн гурван хэсэг, «Эрт үеэс Монголын эзэнт гүрэн мөхөх хүртэл», «Ардын хувьсгалын дараахи Монгол орон», «Монголын ард түмний аж амьдрал», «Найрамдлын хот-Дархан» зэрэг 17 бүлгээс бүрджээ.

Зохиогч номдоо монголын ард түмний түүх, нийгэм соёл, зан заншлыг цухас дурдаад гол нь «цэцэглэн хөгжсөн социалист Монголын өнөөгийн дүр төрхийг өөрийн орны болон гадаадын өргөн олон уншигч нарт танилцуулахыг эрмэлзсэн» нь тэмдэглүүштэй 1939 оны Халх голын дайны үед Монголын хязгаарт долоо, найман жил амьдран сууж бас Өвөр Монголын нутагт ажиллаж байсан (энэ тухай зохиолч номынхоо оршилд дурджээ) Ёсида Минору 40 шахам жилийн дараа «Монголыг үзээд» тэр үеийг одоотой «зүйрлэхийн аргагүй» өөрчлөгдсөнийг нүдээр үзэгчийн хувьд өргөн олон уншигчдад танилцуулахад үнэхээр таарах хүн ажээ. Энэ хугацаанд монголын ард түмний социалист байгуулалтдаа олсон ололт амжилт хэдийгээр зүй тогтолтой хэрэг боловч зохиогчид «гайхамшиг» төрүүлэхгүй байж чадахгүй нь аргагүй юм. Ийм ч учраас зохиогч номоо «Нүүдэлчин үндэстний гайхамшиг» гэж давхар гарчиглажээ.

МАХН, БНМАУ-ын засгийн газраас ардын хувьсгалын жилүүдэд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх талаар авч явуулсан дэс дараатай арга хэмжээнүүдийг зохиогч тодорхой тоо баримтад тулгуурлаж оновчтойгоор дүгнэн бичихдээ 1921 оны Ардын хувьсгалаас өмнө «Боловсрол гэгээрэл гэвэл сүм хийдүүдэд, төвд номыг хоосон цээжлүүлж, эмчилгээ сувилгаа гэвэл лам нарын гүрэм ном, шүтлэг бишрэл төдийхнөөр хязгаарлагдаж, нийгмийн халдварт өвчин дэлгэрэн, хүн ам хорогдож байсан» (25-р тал) Монгол орон одоо «Бичиг үсэг үл мэдэх явдлыг үүрд устгаж, соёл боловсролыг түгээн дэлгэрүүлж, ардын эрүүлийг хамгаалахыг хөгжүүлэхийн зэрэгцээгээр аж үйлдвэрийг, чухалчилан хөгжүүлснээр хоцрогдсон мал аж ахуйн орон эдүгээ аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болтлоо дэвшин дээшилж чадсан байна» (79, 96-р тал) гэжээ.

Зохиогч номдоо Монгол-Хятадын харилцааны байдал, Монголын эсрэг хятадын эзлэн түрэмгийлэгчдээс баримталж ирсэн чиг бодлого, сүүлийн үед Хятадын эрх баригчдаас БНМАУ-д учруулж байгаа аюул заналын талаар нилээд дэлгэрэнгүй бичжээ. Тухайлбал «Хятадууд монголыг түрэмгийлэн эзлэх бодлогыг баримталж ирсэн бөгөөд одоо ч баримталсаар байна. 1962 онд Монголын талын санаачилгаар Монгол Хятад хоёр улсын хилийн гэрээнд гарын үсэг зурсан боловч түүнээс хойш ч хятадын жанжлах үзэлтний түрэмгий бодлого зогсоогүй байна» гээд «Монголын ирээдүйг яагаад ч Бээжинд биш Улаанбаатарт шийдвэрлэх ёстой» (169

171-р тал) хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Ёсида Минору БНМАУ-ын эсрэг хятадын эрх баригчдын явуулж буй цэрэг дайны ажиллагааны тухай бичихдээ: Хятад улс Монголын хилийн орчимд асар их хэмжээний цэрэг бөөгнөрүүлж цэрэг-стратегийн зориулалттай барилга байгууламжийг барьж байгуулан, цэргийн хээрийн сургуулийг үргэлж хийж байгаа ажээ. «Чухамхүү ийм учраас одоо ч гэсэн Зөвлөлтийн цэрэг Монголын засгийн газрын хүсэлтээр монгол нутагт байрлаж, хятадтай залгаа нутгийн түгшүүртэй хилийг хамгаалах үүргийг гүйцэтгэж байна» гэжээ. (39-р тал)

Зохиогч Монгол-Японы харилцаа, тухайлбал худалдаа соёлын харилцааны талаар тодорхой тоо баримттайгаар бичжээ. Цаашилбал энэ номонд Монголын эртний түүх, уран зохиолын дурсгал бичиг «Монголын нууц товчоо» болон түүнийг японд судалсан байдал, монгол, япон хэлний адил төсөөтэй талуудыг харуулсан сонирхолтой баримт дурдсан байна.

Ноён Ёсида Минору манай орны хөгжлийн бодит дүр төрх, монгол-зөвлөлтийн ард түмний найрамдал, хамтын ажиллагааны интернационалч шинж чанарыг зохиолдоо нилээд олон талаар тусган харуулжээ. Гэвч уг зохиол зарим нэгэн ноцтой дутагдлаас чөлөөлөгдсөнгүй. Энэ нь японы милитарист үеийн түүхийн хамгийн эмзэг хэсгийн нэг буюу 1939 онд болсон тэдний хэлдгээр «Номон ханы хэрэг явдал»-ыг тойрсон асуудалтай холбогдож байна. М. Ёсида бичихдээ: «Номон ханы хэрэг явдал нь Халх голыг улсын хил гэж бодож байсан Маньчжоу-гогийн цэрэг, түүнээс 20-иодхон км-ийн өмнө орших Номон ханыг хил гэж бодож байсан Монголын цэрэг хоёрын жижиг, мөргөлдөөн төдий байсан юм. Үүнээс үүдэн том дайн гарсан явдал нь Маньчжоу-гогийн батлан хамгаалалтыг хариуцсан Японы тал, Монголын батлан хамгаалалтыг хариуцсан Зөвлөлтийн тал хоёр уг хэрэгт оролцсоноос болсон юм. Энэ явдал Зөвлөлтийн ялалтаар төгссөн бөгөөд Японы хувьд Өвөр Монголын талаар улс төрийн бодлого явуулахад хэцүү болж, Зөвлөлтийн хувьд түүний арми хүчтэй гэдгээ Монголын олон түмэнд гайхуулсан юм» (37-р тал) гэжээ. Зохиогч ийнхүү 1939 онд БНМАУ-ын эсрэг Японы милитаристуудаас өдүүлсэн түрэмгий дайныг зөвхөн хилийн жижиг мөргөлдөөний хэмжээнд тавихыг оролдсон нь хэдийгээр

Монгол-Японы харилцааг нэг их хөндөхгүй гэсэн зохиогчийн санаа байгаа боловч түүхийн бодит үнэнд таарахгүй, Халх голын дайны үнэн бодит байдлыг гуйвуулсан хэрэг даруй мөн.

«Номон ханы хэрэг явдал» гэдэг нь үнэн хэрэг дээрээ орчин үеийн олон улсын харилцааны түүхэнд дорно зүгт болсон томоохон дайны нэг юм. Уг дайнд нэг талаас милитарист Япон түрэмгийлэл үйлдэж, нөгөө талаас Зөвлөлт, Монгол хоёр социализмын ялалтыг хамтын хүчээр хамгаалж, Зөвлөлтийн арми «хүчтэйгээ гайхуулаад» зогсоогүй, социализмын цэргийн шинжлэх ухаан ялагдашгүй гэдгийг дэлхий дахинд харуулсан билээ.

Зохиогч номдоо манай орны хөгжлийн дүр төрхийг дүгнэж үзэхдээ монголч эрдэмтэн Оуэн Латтиморийн: «Цэцэглэн хөгжиж байгаа өнөөгийн Монгол бол тусламжийн ачаар хурдавчлан хөгжсөн эдийн засгийн хөгжлийн жишээ мөн бөгөөд урьд техник ч байгаагүй, улсын капитал ч байгаагүй, орон улам бүр орчин үеийн улс болсоор байна. Тусламжийн эх булаг нь гадаад улс боловч Монгол орчин үед олон шинэ шинэ үйлдвэрийн газруудыг байгуулж, өөрийн орны боловсон хүчнийг хуваарилах асуудлыг шийдвэрлэж чадсанаараа энэ хөгжил хамгийн өндөр түвшинд гарч, бүх ард түмнийг хамарч чаджээ. Эдийн засаг нь улам улам хөгжиж байна. Үүний улс төрийн үр дүн гэвэл засгийн газар нь ард түмнээрээ хүрээлүүлж, хөгжлийн төлөвлөгөөгөөр дэвшсэн Зөвлөлттэй тогтоосон холбоо нь зөвхөн засгийн газруудын хоорондын зүйл биш ард түмний жинхэнэ өөрсдийнх нь тогтоосон холбоо юм» (41-р тал) гэсэн үгийг иш татжээ.

Эцэст нь хэлэхэд үзсэн харсан үнэн байдал, түүнийг баяжуулах монголын түүхэнд холбогдох ном зохиол, нам төрийн удирдагчдын хэлсэн үг, уулзаж ярилцсан хүний дурдатгал яриа зэргийг өргөн ашиглаж бичсэн ноён М. Ёсидогийн энэ ном монголын ард түмэн ардын хувьсгалынхаа 60-аад жилийн дотор МАХН-ын зөв мэргэн удирдлагаар социализм байгуулах үйлсдээ олсон их амжилт, тэр ололт амжилтын найдвартай баталгаа болсон Монгол-Зөвлөлтийн найрамдлын ач тусыг японы уншигч нарт ерөнхийдөө зөв зүйтэй танлцуулсан бүтээл болжээ гэж үзэлтэй.

**Б. Сэржав**